

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 3 сарын 14 өдөр

Дугаар 60

Улаанбаатар хот

“Хадгаламж, зээлийн хоршооны
зохицуулалтын журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.“Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журам”-ыг нэгдүгээр, хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, гэрчилгээний хавсралтын загварыг хоёрдугаар, хадгаламж, зээлийн хоршооны салбарын гэрчилгээний загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэ журам батлагдсантай холбогдуулан Хорооны 2006 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Батлагдсан журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Д.Нямцэрэн/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, хадгаламж, зээлийн хоршооны салбар нээх зөвшөөрөл олгох, оноосон нэр өөрчлөх, өөрчлөн байгуулах, татан буугдах болон бусад зохицуулалтын асуудалтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хороо хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохдоо хадгаламж, зээлийн хоршоо /цаашид “ХЗХ” гэх/-ны оршин байгаа газар, гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн хэмжээнээс үл хамааран хууль, журамд заасан нөхцөл шаардлагыг тэдгээрт адил, тэгш хангуулах зарчмыг баримтална.

Хоёр. Үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлага

2.1. Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн ХЗХ нь Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан баримт бичгээс гадна энэ журмын шаардлагыг хангасан дараах баримт бичгийг Хороонд ирүүлнэ;

2.1.1. энэ журмын нэгдүгээр хавсралтын дагуу хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдөл;

2.1.2. үүсгэн байгуулах үйл ажиллагааны тайлан;

2.1.3. үүсгэн байгуулах хурлын тэмдэглэл, шийдвэрийн эх хувь;

2.1.4. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 19.1-19.3 дахь хэсэгт заасан нөхцөл шаардлагыг хангасан гишүүний дараах мэдээллийг агуулсан бүртгэл:

2.1.4.1. ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;

2.1.4.2. регистр, иргэний үнэмлэхийн дугаар;

2.1.4.3. оршин суух хаяг, холбоо барих утас;

2.1.4.4. оруулсан хувь хөрөнгийн хэмжээ;

2.1.5. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд нийцүүлэн гаргасан тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хорооны ажиллах журам;

2.1.6. үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах арга хэмжээний талаарх мэдээлэл;

2.1.7. үйл ажиллагааны бусад журам;

2.1.8. тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хорооны дарга, гишүүдийн мэргэжил, мэргэшил, ур чадварын талаар энэ журмын хоёрдугаар хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт болон дараах баримт бичиг:

2.1.8.1. хугацаа хэтэрсэн зээл болон ял шийтгэлтэй эсэх талаар эрх бүхий байгууллагын тодорхойлолт;

2.1.8.2. тухайн сонгуульт ажлыг эрхлэхэд харшлах зүйлгүйг нотлосон ХЗХ-ны тодорхойлолт;

2.1.8.3. сүүлийн гурван жилийн хугацаанд санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаад дампуурсан хуулийн этгээдийн удирдлагад ажиллаж байгаагүй тухай зохих байгууллагын тодорхойлолт;

2.1.8.4. иргэний үнэмлэх, банк, санхүү, хуулийн мэргэжлийн дипломын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, эсхүл орон нутгийн хөгжил, хоршооны талаар мэдлэг, туршлагатайг нотлох зохих байгууллагын тодорхойлолт;

2.1.9. гүйцэтгэх захирал, нягтлан бодогчийн хувьд энэ журмын гуравдугаар хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт болон журмын 2.1.8.1, 2.1.8.2, 2.1.8.3. дэх заалтад дурдсан баримт бичгүүд:

2.1.10. энэ журмын дөрөвдүгээр хавсралтын дагуу гаргасан техник, тоног төхөөрөмж, ажлын байрны тодорхойлолт;

2.1.11. энэ журмын тавдугаар хавсралт дахь зөвлөмжид нийцүүлэн боловсруулсан бизнес төлөвлөгөө;

2.1.12. шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуульд заасан бусад мэдээлэл, тодорхойлолт;

2.2. Хуулийн этгээд гишүүнээр элссэн бол энэ журмын 2.1 дэх хэсэгт зааснаас гадна дараах нэмэлт баримт бичгийг бүрдүүлж ирүүлнэ:

2.2.1. улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

2.2.2. хувь нийлүүлэгчийн овог нэр, регистрийн дугаар, оруулсан хөрөнгийн хэмжээ;

2.2.3. хугацаа хэтэрсэн зээлийн өргүй, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой болон бусад хууль, тогтоомж зөрчсөн үйл ажиллагаа эрхэлж байгаагүй талаарх тодорхойлолт;

2.2.4. ХЗХ-нд гишүүнээр элсэх тайлант үеийн санхүүгийн тайлан;

2.2.5. сүүлийн жилийн үйл ажиллагааны тайлан.

Гурав. Тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн баримт бичгийг хянах

3.1. Хороо Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль, энэ журмыг үндэслэн ХЗХ-ноос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн баримт бичгийг дараах байдлаар хянана:

3.1.1. энэ журмын 2.1, 2.2 дахь хэсэгт заасан баримт бичиг бүрэн гүйцэд, шаардлага хангасан эсэх;

3.1.2. үүсгэн байгуулагч гишүүд нь үүсгэн байгуулах гэрээг байгуулсан, оруулах хувь хөрөнгийн 30-аас дээш хувийг бэлэн мөнгөөр төвлөрүүлснийг нотлох төлбөрийн баримт болон адилтгах бусад баримт бичиг байгаа эсэх;

3.1.3. тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүд, гүйцэтгэх захирал, нягтлан бодогч нь энэ журмын 2.1.8 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан эсэх;

3.1.4. бизнес төлөвлөгөө нь энэ журмын тавдугаар хавсралт дахь зөвлөмжид нийцсэн эсэх;

3.1.5. үйл ажиллагаандаа мөрдөх дүрэм, журам, заавар нь холбогдох хууль, тогтоомжид нийцсэн эсэх;

3.1.6. техник, тоног төхөөрөмж, ажлын байр нь үйл ажиллагаа эрхлэх найдвартай аюулгүй байдлыг хангасан эсэх;

3.2. Хороо шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагаас тодорхойлолт, лавлагаа гаргуулна.

3.3. Баримт бичгийн бүрдэл дутуу, шаардлага хангаагүй, баримт бичгийг зайлшгүй магадлан шинжлэх, нэмж тодруулах шаардлагатай бол энэ тухай тэргүүлэгчдийн зөвлөлд Хороо албан бичгээр мэдэгдэнэ.

Дөрөв. Тусгай зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах

4.1. Тусгай зөвшөөрөл авах хүсэлт, холбогдох баримт бичиг нь Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 15.3 дахь хэсэг, энэ журамд заасан нөхцөл шаардлагыг хангасан тохиолдолд Хорооны хуралдаанаар шийдвэрлэнэ.

4.2. Тусгай зөвшөөрөл олгосон шийдвэрийг үндэслэн холбогдох хуульд заасны дагуу улсын тэмдэгтийн хураамжийг Хорооны дансанд төвлөрүүлсний дараа тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгоно.

4.3. Хорооны шийдвэрийг үндэслэн тэргүүлэгчдийн зөвлөл ХЗХ-г хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлснээр үйл ажиллагаагаа эхлүүлэх ба бүртгүүлснээс хойш ажлын 14

өдрийн дотор улсын бүртгэлийн гэрчилгээ болон дүрмийн эх хувь эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг Хороонд ирүүлнэ.

4.5. ХЗХ нь өөрийн буруугаас тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн баримт бичгийг бүрэн гүйцэд, энэ журмын шаардлагад нийцэхүйц хэмжээнд бүрдүүлэх хугацаа нь анх хүсэлт тавьсан өдрөөс хойш 3 сарын хугацаа өнгөрсөн бол тусгай зөвшөөрөл олгохоос татгалзаж, энэ тухай үндэслэл бүхий хариуг албан бичгээр хүргүүлнэ.

4.6. Хуурамч баримт бичиг бүрдүүлсэн үндэслэлээр тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд уг өдрөөс хойш 1 жилийн дотор хүсэлтийг дахин хүлээж авахгүй.

Тав. Санхүүгийн бусад ажил, үйлчилгээ эрхлэх нэмэлт зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах, хүчингүй болгох

5.1. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13.5 дахь хэсэгт заасан хууль тогтоомжоор хориглоогүй санхүүгийн бусад ажил, үйлчилгээний нэр төрлийг Хороо тогтооно.

~~5.2. Хороо дараах нөхцөл, шаардлагыг хангасан ХЗХ-нд санхүүгийн бусад ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг нэмж олгоно:~~

~~— 5.2.1. Хороонд ирүүлбэл зохих холбогдох тайлан, мэдээ, мэдээллийг сүүлийн 1 жилийн хугацаанд хууль тогтоомж, журам, зааварт заасны дагуу бүрэн гүйцэд ирүүлсэн;~~

~~— 5.2.2. Хорооноос хийсэн газар дээрх хяналт шалгалтаар зөрчил дутагдал илрээгүй, илэрсэн боловч зөрчлийг арилгах талаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт хангагдсан;~~

~~— 5.2.3. Хорооноос баталсан зохиотой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг сүүлийн 2 улирал дараалан тасралтгүй хангаж ажилласан, үйл ажиллагаагаа хэвийн явуулсан;~~

~~— 5.2.4. Хороонд төвлөрүүлэх зохицуулалт үйлчилгээний хөлсийг хугацаанд нь төлсөн;~~

~~— 5.2.5. Хорооноос тухайн ажил үйлчилгээтэй холбогдуулан баталсан журам, заавраар тогтоосон нөхцөл, шаардлагыг хангасан байх;~~

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 371 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон./

5.3. Санхүүгийн бусад ажил, үйлчилгээ эрхлэхийг хүссэн ХЗХ дараах баримт бичгийг Хороонд ирүүлнэ:

5.3.1. өргөдөл;

5.3.2. эрхлэх санхүүгийн бусад ажил үйлчилгээний танилцуулга, холбогдох мэдээлэл;

5.3.3. бүх гишүүдийн хурлын тэмдэглэл, шийдвэрийн эх хувь;

5.3.4. дүрмийн холбогдох өөрчлөлт, санхүүгийн бусад ажил үйлчилгээнд мөрдөх журам;

5.3.5. нэмэлт өөрчлөлт оруулсан бизнес төлөвлөгөө, санхүүгийн үр ашгийн тооцоо.

5.4. ХЗХ-оос ирүүлсэн 5.3-д заасан баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, журам, зааврын дагуу хянаж, тухайн ажил, үйлчилгээ нь ХЗХ-ны санхүүгийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй, гишүүдэд нь хохирол учруулахгүй, боловсон хүчин, техник тоног төхөөрөмж, программ хангамж нь холбогдох нөхцлийг хангасан гэж үзвэл холбогдох санал дүгнэлт гарган Хорооны хуралдаанаар шийдвэрлэнэ.

5.5. Санхүүгийн бусад ажил, үйлчилгээ эрхлэхийг зөвшөөрсөн Хорооны шийдвэр, зохицуулалтын үйлчилгээний хөлс төлснийг нотлох баримтыг тус тус үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад холбогдох тэмдэглэгээ хийнэ.

5.6. Хорооны шийдвэрийг үндэслэн ХЗХ-ны тэргүүлэгчдийн зөвлөл нэмэлт зөвшөөрлийг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлснээр үйл ажиллагааг эхлүүлэх ба бүртгүүлснээс хойш ажлын 14 хоногийн дотор улсын бүртгэлийн гэрчилгээ болон өөрчлөлт оруулсан дүрмийн эх хувь эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг Хороонд ирүүлнэ.

5.7. ХЗХ нь өөрийн буруугаас нэмэлт зөвшөөрөл хүсч ирүүлсэн баримт бичгийг бүрэн гүйцэд, энэ журмын шаардлагад нийцэхүйц хэмжээнд бүрдүүлэх хугацаа нь анх хүсэлт тавьсан өдрөөс хойш ажлын 45 хоногийн хугацаа өнгөрсөн бол зөвшөөрөл олгохоос татгалзаж энэ тухай үндэслэл бүхий хариуг албан бичгээр хүргүүлнэ.

5.8. Нэмэлт санхүүгийн ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг дараах үндэслэлээр хүчингүй болгож, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад холбогдох тэмдэглэгээг хийнэ:

5.8.1. ХЗХ-ны өөрийн хүсэлт;

5.8.2. ажил үйлчилгээтэй холбоотойгоор Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй;

5.8.3. ажил үйлчилгээ нь ХЗХ-ны санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй гэж үзсэн;

5.8.4. Хорооноос хийсэн газар дээрх шалгалтаар хангалтгүй үнэлгээ авсан;

5.8.5. ХЗХ-ны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллаагүй нь тухайн нэмэлт үйл ажиллагаанаас шалтгаалсан нь тогтоогдсон;

5.8.6. хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

**Зургаа. Салбар байгуулахыг зөвшөөрөх,
татгалзах, хүчингүй болгох**

6.1.ХЗХ-ны салбар нь Хорооноос олгосон зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулж тухайн ХЗХ-ны оноосон нэрийг хэрэглэнэ.

6.2. Салбар байгуулах асуудлыг ХЗХ-ны бүх гишүүдийн хурлаар шийдвэрлэнэ.

6.3. ХЗХ нь салбарын байршлыг сонгохдоо дараах нөхцөлүүдийг харгалзан үзнэ:

6.3.1. гишүүнчлэл нь Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 19.3.1, 19.3.2 дахь заалтыг хангасан бол өөр аймаг, хот, суманд салбар нээх;

6.3.2. гишүүнчлэл нь Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 19.3.3 дахь заалтыг хангасан бол тухайн аймгийн сум, тухайн хотын дүүрэгт салбар нээж болно.

6.4. Хороо энэ журмын 5.1, 6.2, 6.3 дахь хэсгүүдэд заасан нөхцөл, шаардлагыг хангасан ХЗХ-нд салбарын нээхийг зөвшөөрнө.

6.5. Салбар байгуулах зөвшөөрөл хүссэн ХЗХ дараах баримт бичгийг Хороонд ирүүлнэ:

6.5.1. өргөдөл;

6.5.2. салбарын үйл ажиллагаа явуулах хүрээ, эрсдэлийг ХЗХ хариуцах тухай бүх гишүүдийн хурлын шийдвэр;

6.5.3. дүрмийн холбогдох өөрчлөлт, салбарын үйл ажиллагаанд мөрдөх журам;

6.5.4. нэмэлт өөрчлөлт оруулсан бизнес төлөвлөгөө, санхүүгийн үр ашгийн тооцоо;

6.5.5. салбарын захирал, нягтлан бодогчийн энэ журмын гуравдугаар хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт болон журмын 2.1.9 дэх заалтад дурдсан баримт бичгүүд.

6.6. Салбар байгуулахыг зөвшөөрсөн Хорооны шийдвэр, зохицуулалтын үйлчилгээний хөлс төлснийг нотлох баримтыг тус тус үндэслэн салбарын гэрчилгээг олгож тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад холбогдох тэмдэглэгээ хийнэ.

6.7. Хорооны шийдвэрийг үндэслэн хадгаламж, зээлийн хоршоодынтэргүүлэгчдийн зөвлөл өөрчлөлт оруулсан хадгаламж, зээлийн хоршооны дүрмийг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлснээр үйл ажиллагааг эхлүүлэх ба бүртгүүлснээс хойш ажлын 14 хоногийн дотор улсын бүртгэлийн гэрчилгээ болон өөрчлөлт оруулсан дүрмийн эх хувь эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг Хороонд ирүүлнэ.

6.8. ХЗХ нь өөрийн буруугаас салбарын зөвшөөрөл хүсч ирүүлсэн баримт бичгийг бүрэн гүйцэд, энэ журмын шаардлагад нийцэхүйц хэмжээнд бүрдүүлэх хугацаа нь анх хүсэлт тавьсан өдрөөс хойш ажлын 45 хоногийн хугацаа өнгөрсөн бол зөвшөөрөл олгохоос татгалзаж, энэ тухай үндэслэл бүхий хариуг албан бичгээр хүргүүлнэ.

6.9. Хороо салбарын зөвшөөрлийг дараах үндэслэлээр хүчингүй болгоно:

6.9.1. салбарыг татан буулгах бүх гишүүдийн хурлын тэмдэглэл, шийдвэр;

6.9.2. Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй;

6.9.3. салбарын үйл ажиллагаа нь ХЗХ-ны санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлсөн болон нөлөөлж болзошгүй гэж үзсэн;

6.9.4. Хорооноос хийсэн газар дээрх шалгалтаар салбарын үйл ажиллагаа нь хангалтгүй үнэлгээ авсан;

6.9.5. ХЗХ-ны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллаагүй нь тухайн салбарын буруутай үйл ажиллагаанаас шалтгаалсан нь тогтоогдсон;

6.9.6. хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

Долоо. Оноосон нэр өөрчлөх

7.1. Оноосон нэрээ өөрчлөхийг хүссэн ХЗХ дараах баримт бичгийг Хороонд ирүүлнэ:

7.1.1. хүсэлт тавьсан албан бичиг;

7.1.2. бүх гишүүдийн хурлын тэмдэглэл, шийдвэрийн эх хувь;

7.1.3. өр төлбөр, өглөг, авлагын дэлгэрэнгүй бүртгэл;

7.1.4. тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, гэрчилгээний хавсралтын эх хувь;

7.1.5. хуулийн этгээдийн улсын бүртгэлээс авсан хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтын хуудас;

7.1.6. бусад шаардлагатай баримт бичиг.

7.2. Энэ журмын 7.1-д заасан баримт бичгийн бүрдэл нь холбогдох нөхцөл, шаардлагыг хангасан, оноосон нэрний өөрчлөлт нь гишүүд, харилцагчдад сөргөөр нөлөөлөхгүй, төөрөгдүүлэхгүй гэж үзвэл Хорооны дарга шийдвэрлэнэ.

7.3. Хорооны даргын шийдвэр, холбогдох заавар, журмаар тогтоосон зохицуулалтын үйлчилгээний хөлс төлснийг нотлох баримтыг тус тус үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээг шинэчлэн олгоно.

7.4. Шийдвэр гаргасны дараа тэргүүлэгчдийн зөвлөл оноосон нэрний өөрчлөлтийг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх ба бүртгүүлснээс хойш ажлын 14 хоногийн дотор улсын бүртгэлийн гэрчилгээ болон өөрчлөлт оруулсан дүрмийн эх хувь эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг Хороонд ирүүлнэ.

Найм. Өөрчлөн байгуулах

8.1. Бүх гишүүдийн хурлын дийлэнх олонхийн шийдвэрт үндэслэн Хорооны зөвшөөрлөөр ХЗХ-г энэ журамд заасны дагуу нийлүүлэх, нэгтгэх замаар өөрчлөн байгуулж болно.

8.2. Өөрчлөн байгуулах зөвшөөрөл хүссэн ХЗХ нь Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 47.3 дахь хэсэгт зааснаас гадна дараах баримт бичгийг Хороонд ирүүлнэ:

8.2.1. гишүүд, тэдгээрийн хадгаламжийн болон зээлийн дэлгэрэнгүй бүртгэл;

8.2.2. өөрчлөн байгуулах үеийн тайлан тэнцэл;

8.2.3. өр төлбөр, өглөг, авлагын дэлгэрэнгүй бүртгэл, өөрчлөн байгуулахад эдгээрийг хэрхэн шийдвэрлэх тухай ХЗХ-ны шийдвэр, холбогдох байгууллагуудтай тооцоо нийлсэн акт, байгуулсан гэрээ;

8.2.4. өөрчлөн байгуулах үйл ажиллагаатай холбоотой удирдлага зохион байгуулалт, гарах зардлыг хэрхэн шийдвэрлэх тухай шийдвэр;

8.2.5. боловсон хүчний асуудлыг хэрхэн шийдвэрлэх тухай шийдвэр;

8.2.6. Хорооноос шаардлагатай гэж үзсэн бусад баримт бичиг.

8.3. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 47.4 заасан хугацаанд асуудлыг хянан шийднэ.

8.4. Хоршоо нь өөрчлөн байгуулах шийдвэр гарснаас хойш ажлын 14 хоногийн дотор Хороо болон гишүүд, харилцагчдад энэ тухайгаа бичгээр мэдэгдэнэ.

8.5. Хоёр буюу хэд хэдэн ХЗХ нь үйл ажиллагаагаа зогсоож, эрх, үүрэг, хариуцлагаа шинээр бий болсон ХЗХ-нд шилжүүлэх замаар нийлүүлэхэд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

8.5.1. нийлж байгаа ХЗХ тус бүрийн тэргүүлэгчдийн зөвлөл нь шийдвэрийн төсөл болон өөрчлөн байгуулах нөхцөл, журмыг тодорхойлсон гэрээ, шинээр байгуулагдах ХЗХ-ны дүрмийн төслийг тус бүрийн бүх гишүүдийн хурлаар шийдвэрлүүлсэн байх;

8.5.2. шинээр байгуулагдах ХЗХ нь энэ журмын 2.1-т заасан баримт бичгийг бүрдүүлж Хороонд ирүүлэх;

8.5.3. нийлэх гэрээнд шинээр байгуулагдах ХЗХ-ны гишүүдийн оруулах хөрөнгө, бүх гишүүдийн хурал хуралдах хугацаа, товыг заасан байх;

8.6. ХЗХ нь үйл ажиллагаагаа зогсоож, эрх, үүрэг, хариуцлагаа өөр ХЗХ-нд шилжүүлэх замаар нэгтгэхэд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

8.6.1. нэгдэж байгаа болон нэгтгэж байгаа ХЗХ тус бүрийн тэргүүлэгчдийн зөвлөл нь нэгтгэх тухай шийдвэрийн төсөл болон өөрчлөн байгуулах нөхцөл, журмыг тодорхойлсон гэрээ, нэгтгэх ХЗХ-ны дүрмийн төслийг тус бүрийн бүх гишүүдийн хуралд оруулж шийдвэрлүүлсэн байх;

8.6.2. өөрчлөн байгуулахыг зөвшөөрсний дараа нэгтгэж байгаа ХЗХ-ны тэргүүлэгчдийн зөвлөл нь нэгдэж байгаа ХЗХ-ны тусгай зөвшөөрлийн гэрчилгээг Хороонд ирүүлэх;

8.6.3. нэгдэж байгаа ХЗХ-г хуулийн этгээдийн улсын бүртгэлээс хасуулж, нэгтгэж байгаа ХЗХ-ны дүрэмд орсон өөрчлөлтийг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх;

8.6.4. Нэгтгэх болон нийлэх замаар өөрчлөн байгуулагдаж байгаа ХЗХ-д нь өөрчлөн байгуулахыг зөвшөөрсөн Хорооны шийдвэр, зохицуулалтын үйлчилгээний хөлс төлснийг нотлох баримтыг тус тус үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээг шинэчлэн олгоно.

Ес. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, сунгах, хүчингүй болгох

9.1. Хороо нь хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ:

9.1.1. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа эрхэлсэн;

9.1.2. Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй;

9.1.3. үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаагүй;

9.1.4. Хорооноос хийсэн газар дээрх хяналт, шалгалтаар хангалтгүй үнэлгээ авсан;

9.1.5. ирүүлбэл зохих санхүүгийн тайлан, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан мэдээг 2 улирал дараалан Хороонд ирүүлээгүй;

9.1.6. холбогдох заавар, журмаар тогтоосон зохицуулалтын үйлчилгээний хөлс төлөх хугацааг аливаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 3-аас дээш сараар хэтрүүлсэн;

9.1.7. гишүүнчлэл нь Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 19.3 дах хэсэгт заасан нөхцөл, шаардлагыг хангаагүй;

9.1.8. хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

9.2. ХЗХ нь зөрчил, дутагдлаа арилгаж, хэвийн үйл ажиллагаагаа хангасан гэж үзвэл түдгэлзүүлсэн хугацаанд багтаан сэргээлгэх хүсэлтээ үүрэг даалгаврын биелэлтийн хамт Хороонд ирүүлнэ.

9.3. ХЗХ-ны хүсэлтийг үндэслэн өгөгдсөн үүрэг даалгавар бүрэн биелэгдсэн гэж үзвэл тусгай зөвшөөрлийг сэргээх асуудлыг Хорооны хуралдаанаар шийдвэрлэнэ.

9.4. ХЗХ нь тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болохоос 45 хоногийн өмнө тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт, дараах баримт бичгийг бүрдүүлж Хороонд ирүүлнэ:

9.4.1. хүсэлт тавьсан албан бичиг;

9.4.2. тэргүүлэгчдийн зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэрийн эх хувь;

9.4.3. энэ журмын тавдугаар хавсралт дахь зөвлөмжид нийцүүлэн боловсруулсан бизнес төлөвлөгөө;

9.4.4. хадгаламж, зээл, хувь хөрөнгө, гишүүдийн дэлгэрэнгүй бүртгэл;

9.4.5. шаардлагатай бусад баримт бичиг;

9.5. Тусгай зөвшөөрлийг сунгахыг зөвшөөрсөн Хорооны шийдвэр, зохицуулалтын үйлчилгээний хөлс төлснийг нотлох баримтыг тус тус үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад холбогдох тэмдэглэгээ хийнэ.

9.6. Энэ журмын 9.1.1-9.1.8 дахь заалтыг зөрчсөн тохиолдолд ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг сунгахгүй байх үндэслэл болно:

9.7. Хороо хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр хүчингүй болгоно.

9.7.1. ХЗХ өөрөө хүсэлт гаргасан;

9.7.2. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 15.9 дэх хэсэгт заасан нөхцөл байдал үүссэн;

9.7.3. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа эрхэлсэн;

9.7.4. тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

9.7.5. Хорооноос хийсэн газар дээрх шалгалтаар хангалтгүй үнэлгээ авсан, цаашид үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжгүй болсон;

9.7.6. гишүүнчлэл нь Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 19.3 дахь хэсэгт заасан шаардлагыг хангаагүй;

9.7.7. түдгэлзүүлсэн хугацаанд Хорооноос өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүй, тусгай зөвшөөрлийг сэргээлгэх тухай хүсэлтийг Хороонд ирүүлээгүй;

9.7.8. Хорооноос өгсөн бусад үүрэг даалгаврыг удаа дараа биелүүлээгүй;

9.7.9. хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

9.8. ХЗХ нь хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосны дараа тусгай зөвшөөрлийн гэрчилгээг Хороонд ирүүлэх үүрэг хүлээнэ.

9.9. Хороо хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай олон нийтэд мэдээлэн, тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд “хүчингүй” тэмдэг дарж, хувийн хэргийн хамт архивт шилжүүлнэ.

Арав. Татан буулгах

10.1. ХЗХ нь эрхлэх үйл ажиллагааны чиглэл, хуулийн этгээдийн хариуцлагын хэлбэрээ өөрчлөх замаар өөрчлөн байгуулагдах, хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн Хорооноос хүчингүй болгосон тохиолдолд ХЗХ-г татан буулгах бөгөөд

холбогдох харилцааг Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 48 дугаар зүйлийг удирдлага болгоно.

Арван нэг. Хяналт, хариуцлага

11.1. Хадгаламж, зээлийн хоршоо холбогдох хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, заавар, шийдвэрийн биелэлтэд Хороо хяналт тавьж зөрчсөн этгээдэд Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 10 дугаар бүлэгт заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-----oOo-----



МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар . . .

. . . оны . . . сарын . . . өдөр

Монгол улсын “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль”, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”, “Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль”, бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны _____ оны _____ сарын _____ өдрийн _____ дугаар тогтоолоор _____-нд

_____ хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА

"Тэмдэг

*Энэ гэрчилгээ нь
хавсралтын хамт
хүчинтэй.*



МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

_____ **ТООТ**
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ

"Тэмдэг"

Хадгаламж, зээлийн хоршоонд зориулсан тэмдэглэлүүд

*Энэ хавсралт нь тусгай
зөвшөөрлийн гэрчилгээний
хамт хүчинтэй*

ДӨРӨВ. Санхүүгийн бусад ажил үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн тэмдэглэл:

Д/д	Зөвшөөрлийн нэр	Зөвшөөрөл олгосон огноо	Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар	Зөвшөөрлийг хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар

ТАВ. Хадгаламж, зээлийн хоршооны салбарын тэмдэглэл:

Д/д	Салбарын нэр, дугаар	Салбарын хаяг, хаягийн өөрчлөлт	Салбарт зөвшөөрөл олгосон огноо	Салбарт зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар	Салбарын зөвшөөрлийг хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар

ЗУРГАА. Тусгай зөвшөөрлийн сунгалтын тэмдэглэл:

Д/д	Сунгалтын тэмдэглэл	Сунгах зөвшөөрөл олгосон огноо	Сунгах зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар	Тэмдэглэл хийсэн огноо, тэмдэг



**МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО
САЛБАРЫН ГЭРЧИЛГЭЭ**

Дугаар ...

... оны ... сарын ... өдөр

Монгол улсын “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль”, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”, “Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль”, бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны даргын _____ оны _____ сарын _____ өдрийн _____ дугаар _____ тушаалыг _____ үндэслэн _____ хот/аймаг/ дахь _____ регистрийн дугаар _____ бүхий _____ тоотулсын _____ бүртгэлийн гэрчилгээтэй _____ оноосон нэр бүхий ХЗХ-нд _____ хот/аймаг/ _____ дүүрэг /сум/

(салбарын нэр, дугаар)

байгуулахыг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА

"Тэмдэг"

Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн эх үүсвэр нь тэдгээрийн хууль ёсны хувийн өмчлөл дэх мөнгөн хөрөнгө болохыг холбогдох баримтад үндэслэн тодорхойлж байна.

Жич: Холбогдох санхүүгийн баримт, тухайн гишүүний тодорхойлолтыг хавсаргах шаардлагатай.

Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 34, 36, 38, 39 дүгээр зүйлд заасан нөхцөл шаардлагийг хангасан тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хороо, гүйцэтгэх албанд дараах нэр бүхий хүмүүс ажиллах болно. Үүнд:

Д/д	Овог,нэр	Одоогийн эрхэлж байгаа ажил	Регистрийн дугаар	Иргэний үнэмлэхийн дугаар	ХЗХ-нд эрхлэх албан тушаал

Өргөдөлд хавсаргасан баримт бичгийн жагсаалт:

1. Хоршооны үүсгэн байгуулах тухай бүх гишүүдийн хурлын шийдвэр хуудас...
2. Хоршооны дүрэм (бүх гишүүдийн хурлаар батлуулж, хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн) хуудас...
3. Эхлэлтийн тайлан баланс хуудас...
4. Үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах хадгаламжийн болон зээлийн үйл ажиллагааны заавар, журам хуудас...
5. Бусад

Жич: Энэ мэтээр өргөдөлд хавсаргасан баримт бичгийг дугаарлан хуудасны тооны хамтаар жагсааж бичнэ.

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар бүрдүүлж хүргүүлсэн баримт бичгүүдийг Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн гаргасан, Хорооны 2012 оны ... дугаар сарын –ны өдрийн дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-д нийцүүлэн үнэн зөв бүрдүүлсэн болно.

Бүрдүүлсэн баримт бичигт ямар нэг буруу, ташаа, хуурамч баримт, мэдээлэл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Өргөдөл, холбогдох баримт бичгийг хүлээн авч, зохих журмын дагуу хянаж, хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож өгнө үү.

ХЗХ байгуулагдсанаас хойшх хугацаанд Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Хорооноос өгсөн үүрэг даалгаврын биелүүлж ажиллах болно.

ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ:

ХЗХ-Г ТӨЛӨӨЛЖ

(тамга тэмдэг)

ХЗХ-ны дарга

/_____//_____/
(овог, нэр) (гарын үсэг)

Тэргүүлэгчдийн зөвлөлийн гишүүн

/_____//_____/
(овог, нэр) (гарын үсэг)

Тэргүүлэгчдийн зөвлөлийн гишүүн

/_____//_____/
(овог, нэр) (гарын үсэг)

ХЗХ-НЫ ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ БОЛОН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ЗӨВЛӨЛ, ХЯНАЛТЫН
ЗӨВЛӨЛ, ЗЭЭЛИЙН ХОРООНЫ ДАРГА, ГИШҮҮДИЙН ТОДОРХОЙЛОЛТ
(Загвар)

А.ХЗХ-той ямар холбоотой болохыг тэмдэглэнэ үү.

1. Үүсгэн байгуулагч	᠑		
2. Гишүүн	᠑		
3. Тэргүүлэгчдийн зөвлөлийн гишүүн	᠑	Дарга	᠑
4. Хяналтын зөвлөлийн гишүүн	᠑	Дарга	᠑
5. Зээлийн хороо	᠑	Дарга	᠑

Б. ХЗХ-нд оруулсан хувь хөрөнгийн хэмжээ: _____

Бэлэнмөнгөөр _____


Эдхөрөнгөөр _____

_____ (_____) төгрөг
(тоогоор) (үсгээр)

Тайлбар:

В. Гишүүд дараах мэдээллийг үнэн зөв бичнэ:

- Овог, нэр:
- Төрсөн он, сар, өдөр:
- Гэрийн хаяг:
- Иргэний үнэмлэхийн дугаар:
- Регистрийн дугаар:
- Холбоо барих утас:



- Боловсролын талаар (Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ)

Д/д	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Орсон он	Төгссөн он	Диплом гэрчилгээний дугаар

- Ажлын туршлагын талаар:

Д/д	Хаана ажиллаж байсан	Албан тушаал	Ажилд орсонон	Ажлаас гарсан он	Шалтгаан

Г. Тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хороо, гүйцэтгэх захирал, ажилтантай нэгдмэл сонирхолтой этгээд эсэх:

Д/д	Таны юу болох	Овог, нэр	Регистрийн дугаар	Иргэний үнэмлэхийн дугаар	Эрхэлж буй албан тушаал

Д. Гэр бүлийн байдал болон яаралтай үед холбоо барих хүн:

Д/д	Таны юу болох	Овог, нэр	Эрхэлж буй албан тушаал	Гэрийн хаяг	Холбоо барих утас

_____ овогтой _____ миний бие _____ ХЗХ-ны гишүүн болж тус ХЗХ-нд оруулж байгаа _____/тоогоор/_____ /үсгээр/төгрөг нь миний хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаанаас олсон орлого бөгөөд холбогдох баримт бичгүүдээ үнэн зөвөөр хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэн танайд хүргүүлсэн болохоо нотлохын зэрэгцээ үүнээс үүсэх аливаа эрсдэлийг хууль тогтоомжийн дагуу бүрэн хариуцахаа илэрхийлж байна.

ХЗХ-Г ТӨЛӨӨЛЖ

(тамга тэмдэг)

ХЗХ-ны дарга:

/_____//_____/
(овог, нэр) (гарын үсэг)

Гишүүн:

/_____//_____/
(овог, нэр) (гарын үсэг)

Тодорхойлолт бичсэн огноо:

ХОРШООНЫГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ БОЛОН ГҮЙЦЭТГЭХ
АЛБАН ТУШААЛТНЫ ТОДОРХОЙЛОЛТ
(Загвар)

1. Хоршооны гүйцэтгэх захирал болон гүйцэтгэх албан тушаалтнууд нь дараах мэдээллийг үнэн зөв бичиж ирүүлнэ:

᠒ овог, нэр:

᠒ эрхлэх албан тушаал:

᠒ төрсөн он, сар, өдөр:


᠒ гэрийн хаяг:

᠒ утасны дугаар:

᠒ иргэний үнэмлэхийн дугаар:

᠒ регистрийн дугаар:

᠒ одоо эрхэлж байгаа ажил:



Боловсролын талаар (Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ)

Д/д	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Орсон он	Төгссөн он	Диплом гэрчилгээний дугаар

Ажлын туршлагын талаар:

Д/д	Хаана ажиллаж байсан	Албан тушаал	Ажилд орсон он	Ажлаас гарсан он	Шалтгаан

2. Тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хороо, гүйцэтгэх захирал, ажилтантай нэгдмэл сонирхолтой этгээд эсэх:

Д/д	Таны юу болох	Овог, нэр	Регистрийн дугаар	Иргэний үнэмлэхийн дугаар	Эрхэлж буй албан тушаал

3. Гэр бүлийн байдал болон яаралтай үед холбоо барих хүн:

Д/д	Таны юу болох	Овог, нэр	Эрхэлж буй албан тушаал	Гэрийн хаяг	Холбоо барих утас

ХЗХ-Г ТӨЛӨӨЛЖ
(тамга тэмдэг)

ХЗХ-ны дарга:

/_____//_____/

(овог, нэр)

(гарын үсэг)

Ажилтан:

/_____//_____/
(овог, нэр) (гарын үсэг)

Тодорхойлолт бичсэн огноо:

"Хадгаламж, зээлийн хоршооны
зохицуулалтын журам"-ын
дөрөвдүгээр хавсралт

ПРОГРАММ ХАНГАМЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ,
АЖЛЫН БАЙР ТОДОРХОЙЛОЛТ

ХЗХ-ны үйл ажиллагаанд ашиглах техник, тоног төхөөрөмжийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

Д/д	Техник, тоног төхөөрөмжийн төрөл	Техникийн үзүүлэлт	Худалдан авсан, түрээслэсэн, гишүүний оруулсан алин болох	Тоо ширхэг

ХЗХ нь дээрх тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, компьютерээс гадна нягтланбодох бүртгэлийн (цаашид зээлийн мэдээллийн санд мэдээ өгч, авах зориулалт бүхий) _____ программыг, _____ (худалдаж авсан, худалдан авах гэж байгаа, гишүүдээс оруулсан эсхүл гэрээ хийсэн байгаа аль нь эсэхийг _____ бичих)

бөгөөд өдөртутмын мэдээ, мэдээлэл боловсруулалтын ажилд компьютерийн энэхүү программашиглах болно.

ХЗХ нь үйл ажиллагаа явуулах байрыг:

Худалдан авсан: 1

Түрээслэсэн: _____ бөгөөд энэхүү байр нь хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны үйлчилгээг эрхлэхэд тохиромжтой, аюулгүй байдлын хувьд бүрэн хамгаалагдсан болно.

Худалдан авсан байрны үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээ

Түрээслэсэн байрны түрээсийн гэрээ

Харуул хамгаалалтыг хэрхэн шийдвэрлэх, шийдвэрлэсэн тухай баримтын хуулбарыг хавсаргав.

ХЗХ-Г ТӨЛӨӨЛЖ

(тамга тэмдэг)

ХЗХ-ны дарга:

/ _____ // _____ /

(овог, нэр)

(гарын үсэг)

Огноо:

"Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журам"-ын тавдугаар хавсралт

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

Өөрчлөн байгуулагдах зөвшөөрөл хүсэх тухай.

Огноо: _____

Хэнээс: _____ /ХЗХ-ны нэр/

Хорооноос анх тусгай зөвшөөрөл авсан шийдвэрийн огноо, дугаар _____

Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлсэн хугацаа _____

Хоршоо тус бүрийнхувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ: _____

Өөрчлөн байгуулагдах хэлбэр: _____

Өөрчлөн байгуулагдаж байгаа ХЗХ-дын нэр:

1. _____
2. _____
3. _____

Өөрчлөн байгуулагдах ХЗХ-ны бүх гишүүдийн хурлын шийдвэр гаргасан огноо;

1. _____
2. _____
3. _____

Өөрчлөн байгуулагдсаны дараа шинээр үүссэн ХЗХ-ны оноосон нэр

Өөрчлөн байгуулагдах болсон үндэслэл, шалтгаан; _____

Жич:Өөрчлөн байгуулагдаж буй үеийн санхүүгийн тайланг хоршоо тус бүрээр хавсаргав.

ХЗХ-Г ТӨЛӨӨЛЖ
(тамга тэмдэг)

ХЗХ-Г ТӨЛӨӨЛЖ
(тамга тэмдэг)

ХЗХ-ны дарга:

ХЗХ-ны дарга:

/ _____ // _____ /

(гарын үсэг) (гарын үсэг)

Огноо:

"Хадгаламж, зээлийн хоршооны
зохицуулалтын журам"-ын
зургаадугаар хавсралт

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨМЖ

1. Бизнес төлөвлөгөө гэдэг нь хадгаламж, зээлийн хоршоо /цаашид ХЗХ гэх/-ны хэтийн зорилго, зорилтыг тодорхойлж, хадгаламж, зээлийн үйл ажиллагааг эрхлэхэд түүний бүтэц, зохион байгуулалт, үйлчилгээний шуурхай, найдвартай ажиллагаа, тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хороо, гүйцэтгэх захирал, гүйцэтгэх албан тушаалтнуудынур чадвар, санхүү, төлбөрийн чадварын үзүүлэлт, үр ашгийг жил тутам сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой цаг хугацаагаар төлөвлөн боловсруулсан бодлогын баримт бичгийн хэлнэ.

2. ХЗХ-ны бизнес төлөвлөгөөг өөрийн үйл ажиллагааны онцлогтой уялдуулан боловсруулах бөгөөд дараах асуудлуудыг заавал тусгасан байна.

Үүнд:

- 2.1. ХЗХ-ны үйл ажиллагаа эрхлэх зорилго, баримтлах бодлого, хэтийн төлөв байдал;
- 2.2. Гишүүнчлэлийн хүрээ;
- 2.3. Удирдлага, гүйцэтгэх албаны бүтэц зохион байгуулалт, орон тоо;
- 2.4. Үйл ажиллагаа, үйлчилгээний танилцуулга;
- 2.5. ХЗХ-ны тайлан тэнцэл, мөнгөн хөрөнгийн урсгал, орлого зарлагын 3 жилийн төсөөлөл;
- 2.6. Актив, пассивын бүтэц, хэмжээ түүний удирдлагыг сайжруулах төлөвлөгөө, хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөлүүд, энэ талаар баримтлах бодлого;
- 2.7. Үйл ажиллагаатай холбогдон гарах эрсдэлийг тодорхойлж, түүнийг удирдахад авах арга хэмжээ;

3. Бизнес төлөвлөгөөг ХЗХ-ны үйл ажиллагаа эрхлэн явуулж эхэлснээс хойш 3-5 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөн боловсруулна.

3.1. Бизнес төлөвлөгөөний нүүр хуудсанд дараах зүйлсийг тусган харуулна:

- ХЗХ-ны нэр, хаяг
- Бизнес төлөвлөгөөний нэр
- Боловсруулсан огноо
- Баталсан шийдвэрийн огноо, дугаар
- Боловсруулсан хүний нэр, хаяг
- Боловсруулсан хүний тэмдэглэл
- ХЗХ-ны удирдлагын нэр, хаяг

3.2. Гүйцэтгэлийн хураангуй

Энэ бүлэгт тухайн бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэгч нь хэрэгжүүлэх гэж буй бизнес төлөвлөгөөний эрхэм зорилго, зорилт, амжилтын үндэс, учирч болох эрсдэл болон санхүүгийн бусад үзүүлэлтүүдийн тухай товч мэдээллийг багтаана.

Эрхэм зорилго гэдэг нь хоршооны гишүүдийн ямар хэрэгцээг, ямар арга замаар хангах тухай тодорхойлолт юм.

Зорилт гэдэг нь эрхэм зорилгод хүрэхийн тулд шат дараалан хэрэгжүүлэх, хугацаатай, хэрэгжилтийг хэмжиж болох бодитой үр дүнгийн төлөвлөлт буюу хүрэх цэг юм.

3.3. Бизнес танилцуулга

Бизнесийн танилцуулга гэдэг нь тухайн Хоршооны нэр, хаяг, өсөж хөгжиж ирсэн түүх, хариуцлагын тогтолцоо, зах зээлийн нөхцөл төлөв байдал, эрхэлж байгаа үйл ажиллагаа, гаргаж буй үйлчилгээ, түүнчлэн удирдлага боловсон хүчний хангалт, санхүүгийн чадавхи ба бизнес төлөвлөвлөгөө бичих болсон шалтгаан, зорилго зорилтууд түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр, зээлийг эргэж төлөх хугацаа, үр ашиг, борлуулалтын орлого зэргийг тусган харуулсан хураангуй тодорхойлолт юм.

Бизнесийн танилцуулга нь дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ:

- Бизнес төлөвлөгөө бичих болсон шалтгаан, зорилго
- Бизнес ба түүний түүх
- Одоо явуулж байгаа үйл ажиллагаа
- Санхүүгийн байдал төлөв
- Зах зээлийн нөхцөл төлөв байдал, цаашдын зорилтууд
- Удирдлага зохион байгуулалт, боловсон хүчин

3.4. Менежментийн төлөвлөгөө

Бизнес төлөвлөгөөний энэ бүлэгт удирдлага, зохион байгуулалт, боловсон хүчний хэрэгцээ гэсэн асуудлуудыг багтааж оруулна.

Удирдах баг: Бизнес төлөвлөгөөний энэ хэсэгт тэргүүлэгчид нь хууль болон банк санхүү, менежментийн чиглэлээр хэр мэргэшсэн, бие биенээ орлох чадвар нь ямар болох, мэргэжил дадлага туршлагатай байх шаардлагыг хэр зэрэг хангасан байдал болон эрх мэдэл, ажил үүргийг оновчтой хуваарилсан байдал зэргийг харуулах хэрэгтэй. Тэргүүлэгчид, Хяналтын зөвлөл болон гүйцэтгэх албан тушаалтанууд (гүйцэтгэх захирал

г.м.), тэргүүлэх ажилтны (салбаруудын удирдлагаг.м.) дадлага, туршлага, тухайн салбарт ажилласан байдал, үүрэг хариуцлага зэрэг тухайн ажил үүргийг гүйцэтгэхэд шаардагдах мэдээлэл бүхий намтрыг бизнес төлөвлөгөөндөө хавсаргах шаардлагатай. Түүнчлэн сонгууль албан тушаалтануудын эрх үүрэг хариуцлагыг нягт тогтоож, хэн нь хэнд захирагддаг, хэн эцсийн шийдвэр гаргадгийг зааж байгууллагын дүрэмд оруулан баталгаажуулж, төлөвлөгөөндөө хавсаргах зэрэг болно.

Зохион байгуулалтын бүтэц: Тэргүүлэгчид нь ХЗХ-ны удирдлага зохион байгуулалтыг шат дамжлага багатай, хамгийн үр ашигтай байхаар бүтцийг тогтоох нь чухал. Цөөн хүнтэй хамт олны зохион байгуулалтын бүтцийн үр ашигтай байх үндэс зарчим нь нэг удирдлагатай байх, ажил үүргийг оновчтой хуваарилах, удирдагч мэдээллээр сайн хангагддаг байх, ажиллагсдын ажлын үр дүнг сонирхдог байх, хяналт ил тод байх явдал болно. Энэ зарчмыг баримтлан зохион байгуулалтын бүтцээ тогтоож, орон тоо, цалин, урамшуулалыг тооцон бизнест төлөвлөгөөндөө оруулна.

Боловсон хүчин: Энэ хэсэгт шаардагдлагатай мэргэжлийн боловсон хүчин тэдгээрийн тоо түүнчлэн мэргэжил эзэмшүүлэх эсвэл мэргэжил дээшлүүлэх сургалтын асуудлуудыг төлөвлөх болно.

Нийт ажиллагсад болон шаардлагатай мэргэжлийн боловсон хүчний хэрэгцээ, уг ажлыг гүйцэтгэх ажиллагсдын тоо түүнчлэн нийт ажиллагсдын сар, жилийн цалин, урамшуулалын хэмжээ, цалингийн шимтгэлийг тооцоолж төлөвлөнө.

Сургалтанд зориулсан зардал хэдийгээр гаднаас нь харахад ашиггүй мэт боловч үр ашгаа зүй ёсоор өгдөг гэдгийг анхаарвал зохистой.

3.5. Санхүүгийн төлөвлөгөө

Санхүүгийн төлөвлөгөөнд дараах хэсгүүд орно. Үүнд:

- Нийт орлогын тооцоо
- Үйл ажиллагааны урсгал зардлын тооцоо
- Алдагдалгүй ажиллагааны тооцоо
- Мөнгөн урсгалын тооцоо гэх мэт.

3.6. Эрсдэлийн шинжилгээ:

Эрсдэлийн төрлүүд:ХЗХ-ны үйл ажиллагаа эрхлэхэд үндсэн 5 төрлийн эрсдэлийгтооцоолоход болно. Үүнд:

- Санхүүгийн болон хадгаламж, зээл;
- Хууль, эрх зүйн зохицуулалтын өөрчлөлт;
- Хүний хүчин зүйлс, засаглал, удирдлага;
- Техник, тоног төхөөрөмж, бүртгэлийн программ;
- Давагдашгүй хүчин зүйл байгалийн гамшиг.

3.7. Эрсдэлийгбагасгахболомжууд

Эдгээр дурдсан эрсдэлээс чухам ямар нь танай бизнест тохиолдож болох магадлал илүү вэ? Түүнийг доод хэмжээнд байлгахын тулд та ямар арга хэмжээ төлөвлөснөө бичих нь зүйтэй. Харин даатгалд үл хамаарах эрсдэлийн талаар авах арга хэмжээг хэрхэн төлөвлөж байгааг тодорхойлох шаардлагатай.